



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Хар хорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 40.0 (дөчин сая) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын биелэлт 87.9 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байх тул дотоод хяналтыг сайжруулж ажиллахыг “Хар хорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал (Ч.Алтанбагана)-д үүрэг болгосугай.

2.“Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.“Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

3.1.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон Гүйцэтгэх захиралтай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ” болон “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

4.“Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал (Ч.Алтанбагана)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

4.1.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

4.2.“Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд туссан зардлаас бусад зардлыг санхүүжүүлэхгүй байх;

4.3.Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын

2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах;

4.4.Бичиг баримтын зөрчилтэй, HVYL-900C жижиг оврын индүү, 05-10 ӨВА дугаартай Зил-130 КО-01 маркийн тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;

4.5.“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газраас хүлээлгэн өгсөн үнэ, үнэлгээ тодорхойгүй, цас цэвэрлэгээний болон нөхөөсний зориулалттай, 2 ширхэг тусгай зориулалт бүхий тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд үнэлж бүртгэх талаар Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх;

4.6.Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд, өссөн дүнгээр 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-д даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн
44 дугаар тогтоолын хавсралт



“Хархорин АЗЗА” төрийн өмчит компанид хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалтыг зөрчин шууд худалдан авалт хийсэн	40.0	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагна журам”-ыг мөрдөж ажиллах.
2	Бичиг баримтны зөрчилтэй 2 тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд тусгасан	-	2 тээврийн хэрэгслийн бичиг баримтын зөрчлийг арилгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах.
Дүн			40.00 (дөчин сая)